# ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2010 ОНЫ УЛСЫН ТООЛЛОГО
## ҮНДСЭН ҮР ДҮН ГАРЛАА

*Хүмүүнд төр эрхэм. Төрд хүмүүн эрдэнэ*

**МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ТОО 2 754 685**
**2010.11.10-НЫ БАЙДЛААР**




**СУУРИН ХҮН АМ**
**2 647 545**

**ГАДААДАД 6 САР, ТҮҮНЭЭС ДЭЭШ ХУГАЦААГААР ОРШИН СУУГАА МОНГОЛ УЛСЫН ИРГЭД**
**107 140**

**ҮҮНЭЭС:**

| | | | |
|---|---|---|---|
| Улаанбаатар | 85758 | Булган | 588 |
| Дархан-Уул | 3978 | Завхан | 557 |
| Орхон | 3581 | Архангай | 505 |
| Баян-Өлгий | 2824 | Хэнтий | 476 |
| Сэлэнгэ | 1780 | Өмнөговь | 459 |
| Төв | 1330 | Увс | 422 |
| Өвөрхангай | 870 | Баянхонгор | 395 |
| Дорноговь | 682 | Говь-Алтай | 368 |
| Дорнод | 679 | Дундговь | 277 |
| Ховд | 617 | Сүхбаатар | 243 |
| Хөвсгөл | 593 | Говьсүмбэр | 158 |

### ХҮН АМЫН ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТ, АЙМАГ, НИЙСЛЭЛ, ХУВИАР, 2000-2010 ОН




Аймаг, нийслэлийн хүн амын тооллого хоорондын жилийн дундаж өсөлтийн дүр төрх ерөнхийдөө төстэй, 1989-2000 онд 5 аймгийн хүн ам өмнөх 10 жилийнхээсээ буурсан байсан. Гэтэл 2000-2010 онд 6 аймаг, нийслэлээс бусад бүх аймгийн хүн амын тоо буурсан нь шилжих хөдөлгөөнөөс хамаарсан. Улаанбаатар хот, Орхон, Өмнөговь аймгийн хүн амын жилийн дундаж өсөлт улсын дунджаас дээгүүр байна.

### ХҮН АМЫН НАС, ХҮЙСИЙН СУВАРГА, 2000, 2010 ОН




Суурин хүн амын 49.5 хувь нь эрэгтэйчүүд, 50.5 хувь нь эмэгтэйчүүд, хүйсийн харьцаа 98.1 байна. Нийт хүн амд 0-14 насныхны эзлэх хувийн жин 27.3, 15-64 насныхан 69.0, 65, түүнээс дээш насныхан 3.7 байна. Хүн ам зүйн ачаалал 2010 онд 45.0 болсон нь 2000 онтой харьцуулахад 19.6 пунктээр буурчээ.

### ХҮН АМЫН ТОО, ЖИЛИЙН ДУНДАЖ ӨСӨЛТИЙН ХУВЬ, ТООЛЛОГО ЯВАГДСАН ОНУУДААР

2000-2010 оны хоорондох хугацаанд суурин хүн ам 381.2 мянган хүн буюу 16.1 хувиар өсч, жилийн дундаж өсөлт нь 1.5 хувь боллоо. Энэ нь 1989-2000 оны хоорондох нийт өсөлтөөс 51.6 мянган хүн буюу 0.1 пунктээр илүү байна. Суурин хүн амын 99.4 хувь нь Монгол Улсын харьяат, 0.6 хувь нь гадаадын харьяат, аль нэг улсын харьяалалгүй хүн 108 байна. Монгол Улсад удаан хугацаагаар оршин суугаа гадаадын харьяат иргэдийн дотор БНХАУ-ын иргэн 8.7 мянга байгаа нь нийт гадаадын иргэдийн 53.2 хувийг, ОХУ-ын иргэн 2.5 мянга буюу 15.2 хувийг, БНСУ-ын иргэн 1.5 мянга буюу 9.3 хувийг, АНУ-ын иргэн 0.7 мянга буюу 4.0 хувийг эзэлж байна. Монгол Улсын харьяат хүн амд халх ястан 82.4 хувийг эзэлж, өмнөх тооллогын үеийнхээс 0.6 пунктээр өссөн байна. Казахуудын тоо өнгөрсөн хугацаанд 0.5 пунктээр буурч, 3.9 хувийг эзэлж байгаа ч халхчуудын дараах хамгийн том үндэстэн хэвээр байна. Дөрвөд, баяд, буриад ястны хувийн жин бараг өөрчлөгдсөнгүй.




### ХҮН АМЫН СУУРЬШИЛ, НЯГТРАЛ

Нийт хүн амд хотын хүн амын эзлэх хувь эрс өсч, 2000 онд нийт хүн амын 57 хувь буюу 1345 мянган хүн хот, суурин газар амьдарч байсан бол 2010 онд энэ хувь 68 (1798.1 мянган хүн) болжээ.

Монгол Улсын нэг квадрат километр нутаг дэвсгэрт 2000 онд 1.5 хүн ногдож байсан бол 2010 онд 0.2 пунктээр өсч, 1.7 болов. Улаанбаатар хот хүн амын нягтралаараа хамгийн өндөр хэвээр байна. Улаанбаатар хотын нэг квадрат километр нутаг дэвсгэрт 2000 онд 162 хүн ногдож байсан бол 2010 онд 246 болж өсчээ.

### ӨРХ, ГЭР БҮЛИЙН БАЙДАЛ, ГЭРЛЭЛТ

Арван тав, түүнээс дээш насны хүн амын 31.3 хувь нь огт гэрлээгүй, 60.1 хувь нь гэр бүлтэй, 3.1 хувь нь салсан, 5.5 хувь бэлбэсэн байгаа бөгөөд анхны гэрлэлтийн дундаж нас эрэгтэйчүүдийн хувьд 26.2, эмэгтэйчүүдийнх 24.2 болж, 2000 оноос 0.5 пунктээр нэмэгдлээ

#### ГЭРЛЭСЭН ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ХҮЙС, ГЭРЛЭЛТИЙН БАЙДЛААР, 2010 ОН

#### ӨРХ, ТҮҮНИЙ БҮТЭЦ, ОРОН СУУЦНЫ НӨХЦӨЛ

Хүн ам, орон сууцны 2010 оны тооллогоор суурин хүн амын 96.5 хувь нь 713.8 мянган өрхөд тоологдсон. Өрхийн тоог 2000 онтой харьцуулахад 31.9 хувиар нэмэгджээ. Нийт өрхийн 10.6 хувь нь ганц бие, 62.3 хувь нь ам бүлээрээ байгаа, 24.9 хувь нь нийлмэл, 2.1 хувь нь холимог ам бүлтэй өрх байна.

Өрхийн ам бүлийн дундаж тоо 3.6 болж, өмнөх тооллогын үеийнхээс 0.7 пунктээр буурав.

мян.хүн

| Насны бүлэг | Эрэгтэй: Огт гэр бүл болоогүй | Эрэгтэй: Гэр бүлтэй[1] | Эрэгтэй: Салсан[2] | Эрэгтэй: Бэлбэсэн | Эмэгтэй: Огт гэр бүл болоогүй | Эмэгтэй: Гэр бүлтэй[1] | Эмэгтэй: Салсан[2] | Эмэгтэй: Бэлбэсэн |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| БҮГД | 322.5 | 568.9 | 25.2 | 20.7 | 273.6 | 577.3 | 33.8 | 84.0 |
| 15-24 | 234.7 | 42.6 | 0.7 | 0.0 | 205.9 | 64.4 | 1.3 | 0.2 |
| 25-34 | 60.7 | 169.9 | 5.4 | 0.4 | 42.4 | 181.5 | 8.0 | 2.1 |
| 35-44 | 18.1 | 160.1 | 9.3 | 1.6 | 14.3 | 158.1 | 12.1 | 8.1 |
| 45-54 | 6.3 | 118.0 | 7.2 | 4.1 | 7.1 | 110.0 | 9.3 | 18.9 |
| 55-64 | 1.6 | 47.7 | 1.9 | 4.3 | 2.2 | 41.4 | 2.3 | 20.1 |
| 65+ | 1.1 | 30.7 | 0.7 | 10.2 | 1.7 | 21.9 | 0.7 | 34.6 |

#### ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2000, 2010 ОН

МЯН.ӨРХ

| БАЙРШИЛ | 2000: Өрхийн тоо | 2000: Дүнд эзлэх хувь | 2010: Өрхийн тоо | 2010: Дүнд эзлэх хувь | 2010/2000 % |
|---|---|---|---|---|---|
| БҮГД | 541.1 | 100.0 | 713.8 | 100.0 | 131.9 |
| Хот | 296.4 | 54.8 | 479.5 | 67.2 | 161.8 |
| Хөдөө | 244.7 | 45.2 | 234.3 | 32.8 | 95.7 |

#### ӨРХИЙН ТОО, ХОТ, ХӨДӨӨ, АМ БҮЛИЙН ТОО, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010 ОН

МЯН.ӨРХ

| БАЙРШИЛ | Бүгд: Өрхийн тоо | Бүгд: Дүнд эзлэх хувь | 1-2: Өрхийн тоо | 1-2: Дүнд эзлэх хувь | 3-4: Өрхийн тоо | 3-4: Дүнд эзлэх хувь | 5-6: Өрхийн тоо | 5-6: Дүнд эзлэх хувь | 7+: Өрхийн тоо | 7+: Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| БҮГД | 713.8 | 100.0 | 190.6 | 26.7 | 337.6 | 47.3 | 154.0 | 21.6 | 31.6 | 4.4 |
| Хот | 479.5 | 100.0 | 124.0 | 25.9 | 229.7 | 47.9 | 102.3 | 21.3 | 23.6 | 4.9 |
| Хөдөө | 234.3 | 100.0 | 66.6 | 28.4 | 107.9 | 46.1 | 51.7 | 22.1 | 8.0 | 3.4 |

(1–10 дугаар баганын ам бүлийн тооны бүлгүүд "Ам бүлийн тоо" гарчгийн дор.)

Нийт өрхийн 45.2 хувь нь гэрт, 53.7 хувь нь байшинд, 1.1 хувь нь бусад төрлийн сууцанд амьдарч байна. Гэрт амьдардаг өрхийн хувь 2000 оноос 5.7 пунктээр буурч, байшинд амьдардаг өрх 5.2 пунктээр нэмэгдлээ. Хотод амьдардаг өрхийн 65.9 хувь нь байшинд, 32.7 хувь нь гэрт амьдарч байгаа нь өмнөх тооллогын үеийнхээс байшинд амьдардаг өрхийн эзлэх хувь буурч, гэрт амьдардаг өрхийнх нэмэгдсэн байна. Нийт өрхийн 12.4 хувь буюу 94.8 мянган өрх өөрийн гэсэн сууцгүй, эдгээрийн 73.9 мянга нь хотын өрхүүд байна.

#### ӨРХИЙН СУУЦНЫ ТӨРӨЛ, 2010 ОН




### БОЛОВСРОЛЫН ТҮВШИН, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

#### АРВАН ТАВ, ТҮҮНЭЭС ДЭЭШ НАСНЫ ХҮН АМЫН ТОО, БИЧИГ ҮСГИЙН МЭДЛЭГ, ХОТ, ХӨДӨӨ, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2010 ОН

мян.хүн

| Бичиг үсгийн мэдлэг | 2000 Бүгд: Дүнд эзлэх хувь | 2000 Хот: Хүний тоо | 2000 Хот: Дүнд эзлэх хувь | 2000 Хөдөө: Хүний тоо | 2000 Хөдөө: Дүнд эзлэх хувь | 2010 Бүгд: Дүнд эзлэх хувь | 2010 Хот: Хүний тоо | 2010 Хот: Дүнд эзлэх хувь | 2010 Хөдөө: Хүний тоо | 2010 Хөдөө: Дүнд эзлэх хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| БҮГД | 100.0 | 898.7 | 100.0 | 625.7 | 100.0 | 100.0 | 1 331.7 | 100.0 | 574.3 | 100.0 |
| Бичиг үсэг мэддэг | 97.8 | 888.4 | 98.9 | 602.0 | 96.2 | 98.3 | 1 319.8 | 99.1 | 553.0 | 96.3 |
| Бичиг үсэг мэддэггүй | 2.2 | 10.3 | 1.1 | 23.7 | 3.8 | 1.7 | 11.9 | 0.9 | 21.3 | 3.7 |

### ЭДИЙН ЗАСГИЙН ИДЭВХИЙН ҮЗҮҮЛЭЛТ, 2010 ОН

